


МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ:

БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН ИРГЭДИЙН
НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА



НИЙГМИЙН ИТГЭЛЦЭЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ТУХАЙ	4
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ	5
СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ БА ОЙЛГОЛТ	6
НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ	8
• НЭГ. БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН ИРГЭДИЙН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ	10
• ХОЁР. МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ: 5 ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ (2017-2022)	19
ДҮГНЭЛТ	25
НОМ ЗҮЙ	26

IRIM судалгааны хүрээлэн нь Монгол Улсад мэргэжлийн, хараат бус судалгааг институтийн түвшинд, тогтвортой хэрэгжүүлж буй анхны байгууллагуудын нэг юм. Бид олон нийтэд хараат бус, чанартай мэдээллийг түгээж, сайн сайхан нийгмийг цогцлоох, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хоорондын хамтын ажиллагааг дэмжих, Монголын хүн амын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорьж байна. IRIM нь Азийн Нийгмийн сайн сайхан байдлын консорциум болон Олон улсын Социологийн холбооны гишүүн юм.

Бидэнтэй холбогдох

Цахим шуудан: contact@irim.mn

Фейсбүүк/ Твиттер хуудас: @IRIMongolia

Вэбсайт: www.irim.mn

Тайланг эш татах

IRIM (2022), "Монголын нийгмийн сайн сайхан байдал ба уур амьсгалын өөрчлөлт" Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн

Тайланг бичсэн:

Лхагваноровын Дашзэвэг, Түмэнжаргалын Элбэрэл, Ганзоригийн Билгүүнзаяа

Хянасан:

Цэвэгдоржийн Болд, Алдарын Долгион, Ганзоригийн Жаргалмаа

Эх бэлтгэл, дизайн

Ганбаатарын Даваа

Мэдэгдэл

Энэхүү тайлангийн агуулга нь судалгааны багийн гаргасан дүн шинжилгээний үр дүн ба IRIM судалгааны хүрээлэнгийн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Тайланг түгээх, дамжуулах, татаж авах болон хэвлэх боломжтой бөгөөд IRIM судалгааны хүрээлэнгийн эх сурвалж ба зохиогчийн эрхийг зохих ёсоор дурдаж тайлангийн хэсгээс эшлэл татаж болно.

СУДАЛГААНЫ ТУХАЙ

IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн бие даасан бүтээгдэхүүн болох “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-г 6 дахь жилдээ хийж гүйцэтгэлээ. Уг судалгаа нь нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Судалгааны хүрээнд жил бүр нийгмийн ялгаатай бүлгүүдийг зорилтот түүврээр сонгон авч тухайн бүлгийн нийгмийн сайн сайхан байдлыг шинжлэх ухааны арга, аргачлалаар цуглуулсан дата мэдээлэлд тулгуурлан тайлбарлахыг зорьдог билээ. Уг судалгаа нь өнгөрсөн хугацаанд дараах онцлогуудыг тусган хийгдэж байв. Үүнд:

- 2016-2019 оны хооронд жил бүр нийгэм цаг үеийн ялгаатай мөчлөгүүдэд мэдээллийг цуглуулж, цаг үеэс хамаарч иргэдийн сайн сайхан байдал хэрхэн өөрчлөгдөж буйг харьцуулан судалж байв.
- 2020 онд “Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал” сэдэвчилсэн судалгааг гүйцэтгэв.
- 2021 онд COVID-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан “Эмч эмнэлгийн байгууллагын ажилтнуудын сайн сайхан байдал” сэдэвчилсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн.

Харин 2022-2023 онуудад судалгааны багийн зүгээс дэлхийн нийтэд нэн тулгамдсан асуудал болоод буй уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг онцолж, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголчуудын мэдлэг, хандлага, дадал

болон гамшиг, эрсдэлд тэсвэрлэж үлдэх байдал нь нийт хүн амын сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилготой ажилласан. Судалгаанд Улаанбаатар хотын бүх дүүрэг, 13 аймаг, 26 сумдаас түүвэрлэсэн 2800 орчим иргэн хамрагдсан бөгөөд үүнээс уур амьсгалаас үүдэлтэй байгалийн гамшигт өртсөн бүлгийг салган бусад ерөнхий бүлэгтэй сайн сайхан байдлыг нь харьцуулах замаар судалгааны үр дүнг илэрхийлсэн.

Судалгааны үр дүнг үндэсний болон орон нутгийн бодлогод уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгах, олон нийтийн ойлголт, мэдлэг, чадварыг сайжруулах үндэсний хэмжээний олон нийтийг хамарсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулахад ашиглах боломжтой. Тиймээс юуны түрүүнд, иргэдийн цаг агаар, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ажиглалтууд, уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх ойлголтууд, санаа зовж буй асуудлууд гэх мэт ерөнхий ойлголт, мэдлэг, хандлагын асуудлуудыг тусгаж өгсөн.

Мөн энэ жилийн тайланд “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны үр дүнг 2017 оны үр дүнтэй харьцуулан, сүүлийн 5 жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийг тайлбарласан нь нийгмийн хөгжил, түүнийг даган Монголчуудын сайн сайхан байдал хэрхэн өөрчлөгдөж буй динамикийг ойлгоход судлаач, мэргэжилтнүүд, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд, шийдвэр гаргагчдад чухал мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны зорилго нь нийт хүн ам, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт өртсөн иргэдийн сайн сайхан байдалд хэр нөлөөтэй болохыг харуулахыг зорьсон. Мөн “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны үр дүнг 5 жилийн интервал (2017 ба 2022)-аар харьцуулалт хийж, хэрхэн өөрчлөгдсөн болохыг харуулав.

Хэмжилт ба дүн шинжилгээ

Сайн сайхан байдал нь Cantril Ladder (өөрийн үнэлгээний шкал) ашиглан хэмжсэн нийлмэл индекс юм. Энэ нь хүмүүсийг өөрсдийн амьдралыг байж болох хамгийн сайнаас (10 эсвэл 7) хамгийн муу (0) хооронд сайн сайхан байдлаа хэрхэн үнэлж байгааг асуудаг. Тайланг энгийн, ойлгомжтой байлгахын тулд сайн сайхан байдлын түвшнийг нэгтгэн, дүгнэж хэмжүүрүүдийг ангилахдаа дундаж утгаар илэрхийлсэн болно. Мөн сайн сайхан байдлын түвшинд шинжилгээ хийхдээ бүлэг хоорондын ялгаатай байдал, сайн сайхан байдлаа хамгийн өндөр болон хамгийн доогуур үнэлсэн бүлэг хоорондын ялгаа, сайн сайхан байдлын үнэлгээнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан болно.

Судалгааны хамрах хүрээ ба түүвэр

Судалгааг 13 аймгийн 26 сум, Улаанбаатар хотын бүх дүүргийг хамруулан зохион байгуулсан бөгөөд нийт 18 ба түүнээс дээш насны 2800 иргэдээс санамсаргүй түүврийн аргаар мэдээлэл цуглуулсан. Энэ нь 95%-ийн итгэлцлийн түвшинтэйгээр, үндэсний хэмжээнд төлөөлөхүйц үр дүнг гаргах боломжтой юм.

Асуулга

Судалгааны асуулга нь дараах бүтэцтэй бөгөөд уг тайланд зөвхөн тойм асуултуудын боловсруулалт, үр дүнг харьцуулан танилцуулсан болно.

- Хүн ам зүйн мэдээлэл
- Итгэлцэл
- Хамтын ажиллагаа
- Амьдралын сэтгэл ханамж
- Амьдралын олон талт байдлын үнэлгээ (domain)
- Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн нөхцөл байдал



СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ БА ГОЛ ОЙЛГОЛТ

Сүүлийн 20 жилийн хугацаанд сайн сайхан байдлын асуудал нь судалгааны сонирхолтой сэдэв байсаар ирсэн. Сайн сайхан байдал гэдэг нэр томъёо нь хүмүүсийн, амьдралыг эергээр мэдэрч, үнэлэх бүх арга замыг багтаадаг. Иймд уг ойлголтоор нийгэм ба хувь хүний субъектив үнэлгээ, мэдрэмж мөн нийгмийн гишүүд хоорондын харилцааг илэрхийлнэ хэмээн ойлгох нь зүйтэй. Энэ утгаараа сайн сайхан байдлыг судалснаар,

1. Амьдралын янз бүрийн туршлага нь хүмүүсийн аз жаргал, амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх боломжийг олгоно.
2. Хүмүүсийн амьдралд тулгарч буй асуудлууд, хамгийн чухал гэж үздэг зүйл нь бодлого боловсруулахад чиглүүлэх боломжийг олгоно.

Иймд бид уг судалгаагаараа дамжуулан

нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор Монголын нийгмийн сайн сайхан байдлыг хэмжихдээ дараах 2 агуулгыг суурь болгосон.

1. **Нийгмийн нийцэл:** Нийгмийн нийцэл (social cohesion) нь нэгдмэл зорилгод хүрэхийн төлөөх нийгмийн аль ч түвшинд хувь хүмүүсийн хамтран ажиллах хүсэл, эрмэлзэл, хамтын ажиллагаанд үндэслэдэг. Нийгмийн нийцэл итгэлцэл, хамтын ажиллагаа гэсэн ойлголтуудаас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, нийгмийн гишүүд бие биедээ болон тодорхой институциудад итгэдэг (Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар, Орон нутгийн засаг захиргаа,

Судалгааны байгууллагууд) байх болон харилцан бие биедээ тусалдаг, хамтарч ажилладаг байх нь судалгаанд оролцогчдын нийгмийн нийцэл нягт байгааг харуулах юм. Мөн уг ойлголтуудыг ашиглахдаа олон улсын бусад судалгаатай харьцуулагдахуйц байх шаардлагыг хангах зорилгоор Дэлхийн үнэт зүйлсийн судалгаа (World Values Survey), Европын нийгмийн судалгаа (European Social Survey)-д ашиглагддаг нийгмийн итгэлцэл, хамтын ажиллагааг хэмждэг асуултуудыг ашиглав.

2. **Субъектив сайн сайхан байдал:** Сайн сайхан байдлын ойлголт нь нийгэм ба хувь хүний субъектив үнэлгээ, мэдрэмж мөн нийгмийн гишүүд хоорондын харилцааг илэрхийлнэ. Тухайлбал, хүмүүс амьдралынхаа утга

учир болох зорилгыг хэрхэн мэдэрч, түүнийгээ тодорхой хугацааны дараа хэрэгжүүлж чадсан эсэх, хэрэгжүүлэхэд саад болж буй, сэтгэл ханамжгүй хүчин зүйлс нь юу байгаа тухай илэрхийлнэ. Эдгээр ойлголтуудаас уг судалгаанд амьдралын сэтгэл ханамжийн ойлголтыг авч үзсэн болно. Ингэхдээ амьдралын сэтгэл ханамжийг ерөнхийд нь, 5 жилийн өмнөх, дараах болон одоо амьдралдаа хэр сэтгэл ханамжтай байгаа тухай үнэлүүлсэн. Мөн амьдралдаа хэр их аз жаргалтай байгаа тухай болон түүнд аюулгүй байдалдаа сэтгэл ханамжтай байдал, байгаль орчны чанарт сэтгэл ханамжтай байдал зэрэг амьдралын чанарыг нь үнэлүүлэн харьцуулсан болно.

Дүрс 1. Сайн сайхан байдлын хувьсагч: Нийгмийн нийцэл

Нийгмийн нийцэл



Хамтын ажиллагаа

Харилцан бие биедээ тусалдаг, хамтардаг байх.



Итгэлцэл бий болох

Нийгмийн гишүүд бие биедээ болон улс төрийн институциудад итгэдэг байх



Бие биеэс харилцан хамаарах

Нийгмийн гишүүдийг нэгтгэж байдаг "адилсал" байх, нийгмийн аль нэг бүлэгт хамаарч буйгаа мэдэрч байх

Дүрс 2. Сайн сайхан байдлын хувьсагч: Субъектив сайн сайхан байдал

Субъектив сайн сайхан байдал



Амьдралын утга учрын үнэлгээ

Аз жаргалтай байдал, эерэг сэтгэл хөдлөлөөс илүү субъектив сайн сайхан байдлыг илэрхийлдэг. Хүмүүсийн амьдралын утга учир болох зорилгыг хэрхэн мэдэрч байгаа, сэтгэл зүйн хувьд хэр хангалуун байгааг илэрхийлдэг.



Сэтгэл хөдлөл

Хувь хүний сайн сайхан байдлыг өдөр тутмын нөхцөл байдал дээр үнэлэхийн тулд хүмүүсийн богино хугацаан дахь мэдрэмж болон сэтгэл санааны байдлын талаар асуудаг.



Амьдралын сэтгэл ханамж

Хүний амьдрал эсвэл түүний тодорхой үеүдийн талаарх хувийн когнитив үнэлгээ. Хүмүүсийн өөрийнхөө амьдралын талаар эргэцүүлэн бодож, ерөнхийдөө амьдрал нь хэрхэн явж байгааг үнэлүүлдэг.

НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхий дахинд нүүр тулж буй томоохон сорилт болж байна. Агаарын дундаж температур нэмэгдэх, байгалийн эрс тэс үзэгдлүүд болон уур амьсгалын гамшигт үзэгдлүүдийн давтамж, эрчимжилт нэмэгдэх зэргээр дэлхий дахинд, нэн ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд, уур амьсгалын хямрал нь ихээхэн сөрөг нөлөөг бий болгож байна.

Монгол Улсын хувьд мөн адил уур амьсгалын өөрчлөлтөд аль хэдийн өртөж эхэлсэн. Үер, ган, зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга гэх мэт цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлүүдийн тоо сүүлийн 20 жилийн хугацаанд сүүлийн 10 жилтэй нь харьцуулахад төрөл зүйл бүрээрээ 2 дахин нэмэгджээ. Мөн манай орны хувьд 1940 оноос хойш 80 жилийн дундаж температур 2.2 градусаар нэмэгдсэн. Тиймээс цаашид ч мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хямрал үргэлжилж, илүү нэмэгдэх хандлагатай байгаа тул улс орнуудын өмнө тулгамдаж буй эдгээр асуудал, хямралуудыг даван туулах чадавх нэн чухал юм.

Харин энэхүү байгалийн гамшиг, хямралыг даван туулах чадавх нь олон нийт болон үндэстний нийгмийн сайн сайхан байдал болон түүний чанартай шууд холбогдолтойг олон судалгаа харуулдаг. Тийм ч учраас уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах нэгэн чухал алхам

нь олон нийтийн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх байдаг.

Нийгмийн бүтцийн хандлагаар авч үзвэл нийгмийн капиталыг (social capital) бүрдүүлдэг бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болох итгэлцэл, нийгмийн сүлжээ зэрэг нь аливаа хямрал, байгалийн гамшиг, хямралын үед ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Нэн ялангуяа эдгээр нийгмийн капитал болон байгалийн гамшигт үзэгдлүүдийн хоорондын холбоо хамаарал нь харилцан уялдаатай шинжтэй байдаг.


Нийгмийн капиталыг хэмжих ойлголтын хүрээнд тайлбарласнаар, нийгмийн сүлжээ нь гамшиг тохиолдох үед болон гамшгийн дараах үед эрсдэлийг бууруулах, авран хайх ажиллагаанд ихээхэн чухал үүрэгтэй бөгөөд мэдээллийн урсгалыг дэмжих, олон төрлийн тусламж дэмжлэгийг бүрдүүлэх, тархаах, даван туулагч, хохирогчдод сэтгэл зүйн дэмжлэг болох зэргээр нөхцөл байдлыг даван туулахад ихээхэн тус дэмтэй байдаг.

Харин нийгмийн итгэлцэл нь гол төлөв гамшгийн дараах нөхцөл байдал буюу сэргэлтийн үед хамтаараа хүчин чармайлт гаргаж, хариу арга хэмжээ авахад ихээхэн чухал үүрэгтэй байдаг байна. Гэвч, нийгмийн итгэлцэл нь их эсвэл бага байх нь гамшгийн төрөл, зэрэг болон тухайн улсын төрийн байгууллагын зүгээс авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний хурд, цар хүрээ зэргээс хамаарч эергээр эсхүл

сөргөөр нөлөөлдөг байна. Эдгээрээс гадна иргэний нийгмийн оролцоо, гишүүнчлэл, улс төрийн оролцоо зэрэг нь гамшиг тохиолдохоос өмнөх урьдчилан сэргийлэх идэвхтэй, үр нөлөөтэй арга хэмжээг төлөвлөх, нөөц бүрдүүлэх, нийгмийн сүлжээг бэхжүүлэх зэргээр гамшгийн үе дэх болон дараах нөхцөл байдлыг даван туулахад ихээхэн ач холбогдолтой байдаг ажээ.

Дээрх судалгаануудын үр дүнгээс харахад уур амьсгалын өөрчлөлтийг бид нийгмийн сайхан сайхныг бүрдүүлэгч хүчин зүйлс

болох итгэлцэл, хамтын ажиллагаа, оролцоо, нийгмийн сүлжээ гэх мэт олон хүчин зүйлсийн тусламжтайгаар эрсдэл, нөлөөлөл багатай даван туулах, урьдчилан сэргийлэх боломжтой нь харагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн өмнөх үед, гамшгийн үед болон дараа нь нийгмийн сайн сайхан байдал хэрхэн өөрчлөгдөж, мөн хэрхэн харилцан бие биедээ нөлөөлж байгааг судалсан судалгаа Монгол орны хувьд дутмаг учраас цаашид нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.



www.iSEE.mn



НЭГ. БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН ИРГЭДИЙН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ

DAESUNGLLEE.COM

1.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж

Энэхүү дэд бүлэгт сүүлийн 12 сарын хугацаанд байгалийн гамшигт үзэгдэлд ямар нэгэн хэлбэрээр өртсөн иргэдийн ерөнхий мэдээллийг байгалийн гамшигт өртөөгүй бусад судалгаанд оролцогчидтой харьцуулж, онцлог ялгаатай байдлыг нь тодорхойлохыг зорьсон.


Ноцтой үйл явдал, гамшигт өртсөн хотын бүсийн оролцогчдын хувь (67.0%) хөдөөгийн бүсийн оролцогчдоос (60.0%) 17.0%-аар их байна. Ноцтой үзэгдэл, гамшигт өртсөн оролцогчдын хувь ойн бүс (49.5%), хээрийн бүс (25.5%), говийн бүсэд (15.8%) амьдардаг оролцогчдын дунд өндөр байв. Тэр дундаа Улаанбаатар хотод амьдардаг иргэд, хөдөө орон нутагт

амьдардаг иргэдээс илүүтэй байгалийн гамшигт нөхцөл байдалтай илүү тулгардаг болох нь ажиглагдсан. Хот суурин газар амьдардаг иргэдийн хувьд үер болон салхи, шуурганаас үүдэлтэй байгалийн гамшигт нөхцөлтэй илүү тулгардаг бол хөдөө, орон нутагт дээрхээс гадна ган, зудтай холбогдсон байгалийн гамшигт өртөх магадлал өндөр байна.


Нийт судалгаанд оролцогчдын 7.0% нь оршин суугаа газартаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ноцтой үйл явдал, гамшигт өртсөн байна. Тэдгээрийн гуравны нэгээс их хувь нь шуурга (35.0%), үер (32.0%)-т өртсөн бол аравны нэг нь зудын аюулд өртсөн байв.

Дүрс 3. Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж


Судалгаанд оролцогчдын байршил, n=2800



Судалгаанд оролцогчдын сууцны хэлбэр n=2800



Иргэдийн өртсөн байгалийн гамшгийн төрөл, байршил, n=196



Уур амьсгалын өөрчлөлт (УАӨ)-өөс үүдэлтэй байгалийн гамшигт өртөж буй бүлгийн тал орчим хувь нь "гэр"-т амьдардаг гэсэн бөгөөд үүнээс үүдэж, үер салхи шуургатай холбоотой эрсдэлд өртөх байдал нь илүү нэмэгдэх хандлагатай байдаг аж.

Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Үндэстний гуравдугаар тайлан илтгэлд, эмзэг байдлын үнэлгээгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс бий болох байгалийн аюулт, гамшигт үзэгдлийн эрсдэл, түүний нүүрлэх нийт хувь хэмжээ 2046-2065 он хүртэл нийт газар нутаг, дийлэнх аймгийн хэмжээнд өсөх хандлагатай гэж тодорхойлжээ. Түүнчлэн, агаарын хэмийн өсөлт зэрэг хүчин зүйлсийн улмаас хэт халалт, ган нэмэгдэх, зудын (Монгол орны онцгой хүйтэн, хахир өвлийн байгалийн үзэгдэл) давтамж ихсэж, эрч нь ширүүсэх төлөвтэй

байна. Аадар бороо ихэссэнээр, хөрсний гулсалт, элэгдэл, үер болох эрсдэл өндөр байна. Гангийн давтамж нэмэгдсэнээр, хуурайшилт, ган гачиг эрчимжиж, бэлчээрийн үржил шимийг багасгаж, цөлжилтийг хурдасгаж байна. Хот суурин газрын хувьд амьсгалын замын өвчлөл, зүрх судасны өвчлөл хүн амын дунд түгээмэл байгаа бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс шалтгаалан нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг (IFRC)-ээс уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хийсэн судалгаанд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөөгөөр зоонозын болон хачигт халдварт өвчлөлийн эрсдэл нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд шууд бусаар нөлөөлж болзошгүй гэж дурджээ.




1.2 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх иргэдийн мэдлэг

Энэхүү дэд бүлэгт сүүлийн 12 сарын хугацаанд байгалийн гамшигт өртсөн болон өртөөгүй бүлгүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэгийн хувьд ялгаатай байгаа эсэхийг тодруулсан үр дүнгүүдийг танилцууллаа.

Нийт оролцогчдоор уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтын түвшнийг нь үнэлүүлэхэд олонх (76.5%) нь ойлголтоо хангалтгүй хэмээн үнэлсэн байна. Бүлгээр нь харьцуулан үзвэл, сүүлийн 12 сард гамшигт өртсөн бүлгийн хувьд ойлголттой хувь нь харьцангуй өндөр байна.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ойлголт, нэр томъёог мэдэж байгаа хувийг харьцуулан харвал, гамшигт өртсөн болон өртөөгүй аль бүлгийн хувьд дэлхийн дулаарал болон хүлэмжийн нөлөө ба хүлэмжийн хийн ялгаруулалтын талаар сонсож байсан хувь төдийлөн ялгаагүй өндөр байна. Харин, уур амьсгалын өөрчлөлт болон озоны давхаргын цооролт хэмээх ойлголтуудын талаар гамшигт өртсөн бүлэг нь өртөөгүй бүлэгтэй харьцуулахад илүү сайн мэдээлэлтэй байна.

Дүрс 4. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх өөрийн мэдлэгээ үнэлсэн байдал, бүлгээр



1.3 Уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн бүлгийн нийгмийн сайн сайхан байдал

1.3.1 Итгэлцэл

Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх буруу ташаа ойлголтууд нийтлэг байдаг бөгөөд үүнийг тодруулах зорилгоор 5 төрлийн ойлголтыг асууж, бүлгээр нь харьцуулан шинжиллээ. Доорх нийтлэг 5 ойлголтыг тус бүрд нь асуухад, нийт оролцогчдоос хамгийн ихдээ 64.0% буруу ташаа ойлголтыг няцааж чадаж байна. Гэвч, нийтлэг байдлаар харахад буруу ташаа ойлголтуудыг үгүйсгэж чадаж байгаа хувь бага байгаа нь харагдаж байна.

няцааж чадсан хувь нь гамшигт өртсөн бүлгийнхний хувьд мэдэгдэхүйц өндөр (59.0%) байна.

Нийт оролцогчдоос УАӨ-ийн талаарх нэмэлт мэдлэг, ур чадвар хэрэгтэй байгаа эсэхийг тодруулж асуухад 54.8 хувь нь маш их хэрэгтэй гэж хариулсан бол 31.5% нь дунд зэрэг, харин 13.8% нь бага зэрэг эсвэл огт хэрэггүй гэж хариулжээ. Шинэ нэмэлт мэдлэг, ур чадвартай болохыг эрэлхийлж буй оролцогчдын хувьд гамшигт өртсөн эсэхээс үл хамааран мэдэгдэхүйц өндөр байна.

Бүлгээр нь харьцуулж харвал, гамшигт өртсөн бүлэг болон өртөөгүй бүлгүүдийн хооронд 4 буруу ташаа ойлголт дээр төдийлөн ялгаагүй ойролцоо хариулт өгсөн бөгөөд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй байна. Харин зөвхөн 'Манай гаригийн дундаж температурын өөрчлөлт нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоогүй юм' гэсэн буруу ойлголтыг

Уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгааныг гамшигт үзэгдэлд өртсөн болон өртөөгүй бүлгүүдийн хувьд аль аль нь үйлдвэрлэлийн буруутай үйл ажиллагаа (45.3%; 34.3%, тус тус), хүний буруутай үйл ажиллагаа (24.8%; 28.7%, тус тус) гэж үзэж байна.

Энэхүү дэд бүлэгт хүмүүс бие биетэйгээ хэрхэн хамтран ажиллаж, нийгэм, бусад байгууллага болон бусдад итгэх итгэлцлийн түвшин хэр байгааг судалсан.

Гамшигт өртсөн бүлгийн хувьд гамшигт өртөөгүй бүлэгтэй харьцуулахад бусдад итгэх байдал нь статистикийн хувьд ач холбогдол бүхий өндөр байна. Мөн гэр бүл, ойр дотно хүмүүстээ итгэдэг ч, тэднээс бусад өөр өөр газар нутаг, үндэс угсаатай хүмүүст илүү болгоомжтой хандаж байна. Энэ нь аливаа зан үйлийг өөрчлөх, олон нийттэй харилцах ажлуудыг алсын зайнаас биш, нүүр тулж шийдэх, олноороо хамтран ажиллах байдлаар зохион байгуулах нь чухал болохыг харуулж байна.


байгаа ч, тэдэнд итгэх итгэл бага байгаа нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнд саад болж болзошгүй.

Харин Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газарт итгэх итгэл нь бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгааг анхаарах хэрэгтэй. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтийг хамарсан ажил зохион байгуулахад итгэл хүлээсэн шинжлэх ухааны байгууллагуудыг мэдээллийн эх сурвалж болгон ашиглах боломжийг бүрдүүлж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ, олон улсын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, судалгааны байгууллагуудад итгэх итгэл нь дундаж байна.


Хүмүүсийн дунд институт, ялангуяа төр ба шийдвэр гаргагчдад итгэх итгэл бага байна. Үр дүнгээс харахад улс төрч, хууль тогтоогчдод итгэх итгэлд 2.85 оноо өгсөн бол, засгийн газрын шийдвэр гаргагчдад харьцангуй өндөр 4.65 оноо өгсөн байна. Хэдийгээр Монголчууд засгийн газрыг эрчим хүч, хөдөө аж ахуйн хог хаягдлын менежмент, дэд бүтэц, байгаль орчин зэрэг гол салбарт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж

Судалгаанд оролцогчдын бусдад итгэх байдлыг илтгэсэн судалгааны үр дүнд тэдний ажлын нөхцөл болон хүн ам зүйн мэдээллээс нь хамаарсан ялгаатай байдал ажиглагдсангүй. Тухайлбал тэдний ажилладаг байгууллагын статус, албан тушаал, цалин, ажлын цаг, нас, хүйс, боловсролын түвшин зэргээр статистик тест хийж үзэхэд ач холбогдол бүхий ялгааг харуулсангүй.

Дүрс 5. УАӨ-ийн талаарх буруу ташаа ойлголтууд ба тэдгээрийг няцааж чадсан оролцогчдын хувь, бүлгээр




Дүрс 6. Судалгаанд оролцогчдын итгэлцлийн дундаж түвшин




'Ерөнхийд нь авч үзвэл бусад хүмүүст итгэж болно гэж боддог уу? эсвэл маш болгоомжтой харилцах шаардлагатай гэж боддог уу? (0=Маш болгоомжтой байх хэрэгтэй 10=Ихэнхи хүмүүст итгэж болно)

Дүрс 7. Судалгаанд оролцогчдын итгэлцлийн түвшний дундаж

Судалгаанд оролцогчдын нийгмийн бүлгүүдэд итгэх байдлын дундаж утга



Судалгаанд оролцогчдын нийгмийн институциудад итгэх байдлын дундаж утга



1.3.2 Хамтын ажиллагаа

Хүмүүс хоорондын хамтын ажиллагааны чухал үзүүлэлтийн нэг нь тэдний янз бүрийн сайн дурын, улс төрийн болон/эсвэл мэргэжлийн байгууллага, холбоодын гишүүнчлэлтэй эсэх юм. Үүнд, хувь хүмүүст нийгэмтэйгээ өргөн цар хүрээнд холбогдож, өөрчлөлт хийхэд нь дэмжиж, тулгарч буй асуудлуудаа шийдвэрлэх боломж олгодог янз бүрийн байгууллага, бүлэг багтана.

Гамшигт нөхцөл байдалд өртсөн бүлгийн иргэд нь ямар нэгэн байгууллага, бүлэглэлд гишүүнчлэлтэй байх тохиолдол гамшигт өртөөгүй бүлэг иргэдээс илүү байна. Хамгийн нийтлэг дурдагдсан байгууллагууд нь спорт, биеийн тамир, урлаг, соёлын бүлгүүд байгаа бөгөөд энэ нь нэг талаас, уур амьсгалын талаарх бодлого, эн тэргүүнд анхаарах зүйлс, асуудлуудын чиглэлээр байгаль орчны байгууллага, хөдөлгөөн, орон нутгийн зөвлөл, хамтран ажиллагч, улс төрийн намуудаар дамжуулан мэдлэг, чадварыг дээшлүүлж батжуулах орон зай байгааг харуулж байна. Ингэснээр иргэдэд илүү хүрч, санаа зовниж буй асуудлаа илэрхийлэх боломж олгоно.

Нөгөө талаас хүмүүсийн дунд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, гамшгийн бэлэн байдлыг сайжруулах, өөрчлөгдөж буй орчин нөхцөлд илүү дасан зохицоход оролцох, хувь нэмрээ оруулах сонирхол, эрэлт хэрэгцээ харагдаж байгаа бөгөөд эдгээрийг тогтвортой, үр дүнтэй стратеги бүхий үйл ажиллагаануудаар дамжуулан хангаж болно.

Газар хөдлөлт, ой хээрийн түймэр, үер, ган, зуд гэх мэт байгалийн гамшиг тохиолдсон үед янз бүрийн бүлгүүд өөрийг нь дэмжихэд бэлэн гэдэгт итгэлтэй хүмүүсийн хувь харьцангуй өндөр байна. Судалгаанд хамрагдсан бараг бүх хүн төрөл төрөгсөд, дотно найз нөхөд, онцгой байдлын мэргэжилтнүүд болон байгалийн гамшгийн үед анхны тусламж үзүүлэгчдэд туслахад бэлэн байгаагаа илэрхийлсэн нь тэргүүн эгнээний байгууллага, яаралтай тусламж үзүүлэгчдэд итгэх итгэл өндөр байгааг харуулж байна. Сонирхолтой нь, гамшгийн үе дэх сайн дурын тусламжийн байгууллага, ТББ-уудаас тусламж авахаасаа (56.1%, 53.6%) илүүтэйгээр, эдгээр байгууллагад тусална гэж хариулсан хувь (73.6%, 70.1%) өндөр байна.

Дүрс 8. Судалгаанд оролцогчдын хамтын ажиллагааны түвшин

Ямар нэгэн байгууллагад гишүүнчлэлтэй эсэх



Байгалийн гамшгийн үед бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх байдал



1.3.3 Амьдралын сэтгэл ханамж


Амьдралын сэтгэл ханамж гэдэг нь хүмүүс өөрсдийн амьдралаа хэрхэн үнэлж буй хэмжүүр юм. Энэ нь хүний амьдрал эсвэл түүний тодорхой үеүдийн талаарх хувийн когнитив үнэлгээ юм.

Уг үзүүлэлтийг тодорхойлохдоо “Кантрилийн шатлал” буюу оролцогчдыг 0-ээс 10 хүртэлх гишгүүртэй шат төсөөлж өөрийн амьдралыг аль шатанд байгааг үнэлүүлдэг. 10 оноо нь байж болох хамгийн сайхан амьдралыг, харин хамгийн доод гишгүүр буюу 0 нь амьдралын байж болох хамгийн муу түвшнийг илэрхийлнэ.

Байгалийн гамшигт өртсөн иргэд өртөөгүй иргэдтэй харьцуулахад амьдралын сэтгэл ханамж доогуур байна. Иргэд 5 жилийн өмнөх үнэлгээнээс одоогийн нөхцөл байдлаас өндөр, ирээдүйн 5 жилийн нөхцөл байдлаа одоогийн нөхцөл байдлаас өндөр төсөөлсөн байдал нь ижил байв.

Илүү орлоготой хүмүүс амьдралдаа илүү сэтгэл ханамжтай байсан бөгөөд орлогын түвшин нь амьдралын сэтгэл ханамжийг өндөр түвшинд байлгахад хамгийн их нөлөөлж байна. Түүнчлэн нас, хүйс, боловсролын түвшин болон суурьшлын төрөл зэрэг нь амьдралын сэтгэл ханамжийн үнэлгээнд нөлөөтэй байна.

Дүрс 9. Амьдралын сэтгэл ханамжийг цаг хугацааны интервалаар харуулсан үр дүн



ХОЁР: МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ: 5 ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ (2017-2022)

2.1 Монголын нийгмийн сайн сайхан байдал: 5 жилийн өөрчлөлт


Уг бүлэгт бид "Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа"-ны үр дүнг 2017 оны үр дүнтэй харьцуулан, сүүлийн 5 жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийг тайлбарласан болно. Энэ нь нийгмийн хөгжил, түүнийг даган Монголчуудын сайн сайхан байдал хэрхэн өөрчлөгдөж буй динамикийг ойлгоход тус нэмэр болох юм. Энэ бүлэг нь Монголчуудын сайн сайхан байдлыг илэрхийлэх "итгэлцэл, хамтын ажиллагаа, амьдралын сэтгэл ханамж" гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

2.1.1 Итгэлцэл

Ерөнхийд нь хэлбэл ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу эсвэл хүмүүстэй харилцахдаа маш болгоомжтой байх шаардлагатай гэж боддог уу? (0=Маш болгоомжтой байх хэрэгтэй; 10=Ихэнх хүмүүст итгэж болно)

Иргэдээс 2017 онд бусдад хэр их итгэдэг талаар 0-10 оноогоор үнэлүүлэхэд дунджаар 4.7 буюу хүмүүст тийм ч амар итгэхгүй байгааг харуулсан байна. Харин 2022 онд дахин үнэлүүлэхэд итгэлийн түвшин 4.2 болтлоо буурчээ. Олон

Дүрс 10. Ерөнхий итгэлцлийн дундаж, оноор



улсын түвшинд харьцуулбал (Дэлхийн үнэт зүйлийн судалгааны үр дүнгийн (2010) талаарх Ларсений дүн шинжилгээнд (2014) 52 орны тавд нь л "бусдад итгэдэг" гэсэн хариулт "бусдад итгэдэггүй" гэснээсээ өндөр байдаг. Түүнчлэн Ларсен (2014) "нийгмийн итгэлцэл өндөр түвшинд байх нь ховор үзэгдэл юм" хэмээн онцолсон байдаг. Үүнтэй адилаар 2017 онд Монголд ч мөн хүн амын талаас илүү хувь нь (61% нь 0-5 хүртэлх оноогоор үнэлсэн) "бусдад итгэдэггүй" гэж хариулсан байсан бол 2022 онд 0-5 хүртэлх оноогоор үнэлсэн буюу бусдад итгэхгүй байх хүн амын хувь 69.9% болж нэмэгдсэн байна.

Цаашлаад, иргэд хоорондын итгэлцлийг 2017-2022 оны аль ч судалгаанаас харахад хүйс, хот хөдөөгийн ялгаа, ажил эрхлэлт болон гэр бүлтэй байгаа эсэхээс хамаарсан статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдаагүй болно. Энэ нь хүмүүсийн итгэлцэл өндөр эсвэл бага байх нь хүйс, хот хөдөөгийн ялгаа, ажил эрхэлдэг эсэх, гэр бүлтэй эсэхээс үл хамааран ялгаагүй үнэлэгдэж байна.


Итгэлцлийн талаар илүү нарийн тайлбар өгөхийн тулд бид судалгаандаа нийгмийн ерөнхий итгэлцэл болон тухайлсан итгэлцлийн аль алиных нь статусыг, мөн итгэлцэл чухам ямар харилцан ойлголцол дээр Монголын нийгэм тулгуурладаг болохыг судлахыг оролдсон. Ингэхдээ хувь хүмүүс хоорондын итгэлцэл болон институциудад итгэх итгэлийг судлав.

2017 оны судалгаагаар иргэдийн хувь хүмүүс хоорондын итгэлцлийг судлахад, танихгүй хүмүүст (3.6) хамгийн бага, харин

өөрийн гэр бүлийнхэнд (9.8) хамгийн их итгэдэг гэсэн үр дүн гарчээ. Үүнийг 5 жилийн дараа буюу 2022 онд дахин судлахад танихгүй хүнд итгэх итгэлийн дундаж утга 0-10 хооронд үнэлүүлэхэд 2.0 болж огцом буурчээ.

Энэ нь Монголд хувь хүмүүсийн хоорондын итгэлцэл бусад нийгмийн бүлгүүдэд итгэхээсээ илүүтэй гэр бүлийн харилцаанд төвлөрсөн шинжтэй байна гэсэн 5 жилийн өмнөх үр дүнг дахин бататгаж байна.

Дүрс 11. Хувь хүмүүс хоорондын итгэлцлийн дундаж, оноор




2.1.2 Хамтын ажиллагаа

Бид судалгаанд оролцогчдын хамтын ажиллагаатай холбоотой туршлагынх нь талаар судалсан билээ. Үр дүнд нь, **2017 болон 2022 оны хооронд ямар нэгэн байгууллагуудад гишүүнчлэлтэй эсэх нь хугацааны хувьд ялгаатай үнэлэгдэж, өөрчлөгдсөн эсэхийг судлахад статистик ач холбогдолтойгоор 2017 оныг 2022 онтой харьцуулахад ялгаатай үнэлэгджээ.**

Тодруулбал, улс төрийн намын гишүүнчлэлтэй хүмүүс 17.6%-ийг эзэлж байсан бол 2022 онд 20.2% болж бага зэрэг нэмэгдсэн байна. Харин улс төрийн намаас бусад байгууллагуудын гишүүнчлэл бүгд буурчээ.

Цаашлаад, судалгаанд оролцогчдын нийгмийн идэвх, оролцоондоо хэр сэтгэл ханамжтай байгааг 0-10 оноогоор үнэлүүлэн судлахад 2017 онд дундаж оноо 7.2 байсан бол 2022 онд 6.7 болж буурсан байна. Энэ нь 2017 оноос 2022 оны хооронд иргэдийн нийгмийн итгэлцэл, хамтын ажиллагааны идэвх буурсан нь тэдний амьдралын сэтгэл ханамжийн нэг тал болох нийгмийн идэвх, оролцоондоо сэтгэл ханамжтай байгаа байдал буурахад нөлөөлсөн байгааг харуулж байна.

Дүрс 12. Байгууллагын гишүүнчлэлтэй эсэх



2.1.3 Амьдралын сэтгэл ханамж


Амьдралын сэтгэл ханамжийг тодорхойлохдоо “Кантрилийн шатлал” буюу оролцогчдыг 0-ээс 10 хүртэлх гишүүртэй шат төсөөлж өөрийн амьдралыг аль шатанд байгаагаар үнэлүүлсэн. Шатны хамгийн дээд гишүүр буюу 10 оноо нь байж болох хамгийн сайхан амьдралыг, харин хамгийн доод гишүүр буюу 0 нь амьдралын байж болох хамгийн муу түвшнийг илэрхийлнэ.

2017 онд судалгаанд оролцогчид өөрсдийн амьдралаа ерөнхийд нь үнэлэхдээ сэтгэл ханамж сайтай байсан бөгөөд 2022 онд ч мөн ижилхэн үр дүнг үзүүлсэн байна. Түүнчлэн 5 жилийн өмнөх амьдралдаа хэр сэтгэл ханамжтай байсан тухай, одоогийн амьдралдаа хэр

их сэтгэл ханамжтай байгаа тухай болон 5 жилийн дараах ирээдүйд амьдралдаа хэр сэтгэл ханамжтай байх тухай судалгаанд оролцогчдоос асуухад амьдралын сэтгэл ханамж нь өмнө, одоо, ирээдүйд ч өссөн, өөдрөг үнэлгээг өгчээ.

Энэ нь бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм. Тухайлбал Скандинавын орнууд дахь амьдралаа ерөнхийд нь үнэлж буй сэтгэл ханамжийн үзүүлэлт дунджаар 7.5 байдаг бол Сиричүүд, Бурундичууд болон Төв Африкийн орнуудад амьдралын сэтгэл ханамжийн үзүүлэлт хамгийн бага буюу 3.0 байдаг (Gallup-ын Дэлхий нийтийн Судалгаа 2017).

Дүрс 13. Амьдралын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээний үр дүн, оноор



Дүрс 14. Амьдралын сэтгэл ханамжийг цаг хугацааны интервалаар харуулсан үр дүн, оноор




Иргэдээс 10 хүртэлх гишгүүртэй шат төсөөлж өөрийн амьдралыг аль шатанд байгаагаар нь үнэлүүлсэн. Ингэхэд 2017 онд “5 жилийн дараах” амьдралыг нь үнэлүүлэхэд 0-10 онооноос дунджаар 7.9 буюу 7-8 гишгүүр хооронд байна гэж үнэлж байв. Харин 2022 онд буюу 5 жилийн дараа “одоо байгаа” амьдралыг нь үнэлүүлэхэд 6-7-р шатны хооронд байгаагаар үнэлжээ. Сүүлийн 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулахад Монгол улсын хувьд чухал ахиц дэвшил гаргасан ч сүүлийн жилүүдэд өсөлт тогтворгүй, удааширсан байна. Ажлын байр бий болгох нь Монгол улсын хувьд, ялангуяа залуучуудын дунд тулгамдсан асуудал хэвээр байна.

Эдгээр сорилтуудыг шийдвэрлэхээр засгийн газраас ихээхэн дэмжлэг үзүүлсэн

ч иргэд болон эдийн засагт ихээхэн хохирол учруулсан COVID-19 тахлын улмаас улам бүр дордсон нь иргэдийн 5 жилийн дараах амьдралаа өөдрөгөөр үнэлж байсан үнэлэмжид нөлөөлсөн байж болох юм.

Цаашлаад, иргэд сайн сайхан байдлаа үнэлэхэд юу нөлөөлж буй талаар буюу тэдний амьдарч буй орчин, аюулгүй байдал буюу иргэдийн амьдралын сэтгэл ханамжийг олон талаас нь судлах зорилгоор тэдний аюулгүй орчин, байгаль орчны чанарт хэр их сэтгэл ханамжтай байгааг судалсан. *Үр дүнд нь судалгаанд оролцогчид гадаад орчин буюу аюулгүй байдлаа үнэлэхдээ 2017 оныг бодвол 2022 онд илүү сэтгэл ханамж нь дээшилсэн харагдаж байгаа бол амьдарч буй орчны нь чанарыг үнэлүүлэхэд 2017 оноос 0.7-оор сэтгэл ханамж нь буурчээ.*

Дүрс 15. Амьдралын сэтгэл ханамжид нөлөөлөгч хүчин зүйлс, дундаж утгаар



ДҮГНЭЛТ

Монголчууд бол гэр бүл суурьтай, хүмүүс хоорондын итгэлцэл нь бусад нийгмийн бүлгүүдэд итгэхээсээ илүүтэй гэр бүлийн харилцаанд төвлөрсөн шинжтэй байдаг. Сүүлийн 5 жилд хийсэн судалгааны үр дүнгүүдэд амьдралын сэтгэл ханамж бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр, ирээдүйгээ илүү эергээр төсөөлөх хандлагатай зэрэг Монголчуудын нийтлэг шинж төлөвүүд ажиглагдаж байна. Энэ жилийн тайлангийн гол онцлог нь сүүлийн жилүүдэд дэлхий нийтийн анхаарлын төвд орж, нийгмийн тулгамдсан асуудал болоод буй уур амьсгалын өөрчлөлт хүмүүсийн нийгмийн сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж буйг тодруулах явдал байсан.

Ерөнхий төлөв байдлыг харвал, сүүлийн 5 жилд Монголчуудын нийгмийн сайн сайхан байдалд орсон өөрчлөлтүүдийг харвал хүмүүсийн бие биедээ итгэх итгэлцэл, ялангуяа танихгүй хүнд итгэл итгэл, мөн олон нийтийн хамтын ажиллагааны идэвх оролцоо зэрэг үзүүлэлтүүд үндэсний хэмжээнд буурсан байна. Гэвч сүүлийн жилүүдэд давтамж нь нэмэгдэж буй гамшигт үзэгдлүүдийн үед бий болсон туршлагаудыг үзвэл эрс тэс онцлог олон дүнгүүд харагдаж байна. Тухайлбал, байгалийн гамшигт өртсөн иргэдийн бусдад итгэх итгэл, бусдад туслах эрмэлзэл, хамтын ажиллагааны үзүүлэлтүүд байгалийн гамшигт өртөөгүй иргэдтэй харьцуулахад илүү өндөр байна. Энэ нь аливаа байгалийн эрсдэл, гамшиг тулгарсан үед иргэд нь бие биедээ туслах, хамтдаа гамшигийг даван туулах нийгмийн капиталын үзүүлэлтүүд нь жирийн үетэй харьцуулахад өндөр болдгийг харуулж байна.

Хэдийгээр иргэдийн дунд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох санаачилгуудад хувь нэмрээ оруулах, бусдад хамтран ажиллах, бусдад туслах эрмэлзэл өндөр байгаа ч, дасан зохицох, урьдчилан сэргийлэх, даван туулах ойлголт, мэдлэг хангалтгүй байна.

Байгалийн гамшигийн үед санхүү, хүн хүч, техникийн нөөц хязгаарлагдмал байдал нь алслагдмал, эмзэг бүлгийн иргэдэд хүрч чадахгүй байх эрсдэлүүдийг бий болгодог. Гэвч, түүнийг эрсдэл багатай даван туулж, хурдан шуурхай арга хэмжээ авахад олон нийтийн мэдлэг, ойлголт, нөөц нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс Монгол орон шиг тархсан, алслагдмал газар нутагтай, нөөц хязгаарлагдмал улсын иргэдийн хувьд бие биедээ туслах, хамтран ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлэх, чадавхыг нь бэхжүүлэх нь гамшигийг эрсдэл, хохирол багатай даван туулахад тусална. Нэн ялангуяа, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, зан үйлд нөлөөлөх ажлуудыг авч хэрэгжүүлэхдээ эрсдэлүүдийг нь тооцож, ижил төрлийн эрсдэл бүхий бүлгүүдэд эрсдэлийг нь таниулах, хамтдаа урьдчилан сэргийлэх, даван туулах арга замыг нь зааж өгөхөд анхаарах нь зүйтэй.

Мөн иргэдийн дунд төрийн институт, ялангуяа шийдвэр гаргагч нарт итгэх итгэл бага байгаа хэдий ч Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг мэргэжлийн болон шинжлэх ухааны байгууллагуудад итгэх итгэл нь бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр байна. Мөн уур амьсгал, байгаль орчны чиглэлээр эдгээр байгууллагуудаас өгч буй мэдээлэлд иргэд илүү итгэлтэй хандаж байгаа юм. Тиймээс энэ төрлийн ажлыг зохион байгуулахдаа мэргэжлийн, шинжлэх ухааны байгууллагуудын оролцоог хангах нь үр дүнтэй харагдаж байна.

НОМ ЗҮЙ

- Beauvais, Caroline & Jenson, Jane. (2003). The Well-being of Children: Are There "Neighborhood Effects".
- Aldar, Dolgion & Chultemsuren, Tamir (2015). Defining social cohesion research design and indicators: in the case of Mongolia. National University of Mongolia
- <https://nema.gov.mn/n/113905>
- 'How to measure social capital', Institute for Social Capital, 2017. <https://www.social-capitalresearch.com/measure-social-capital/>
- 'Disasters, Trust, and Social Cohesion, Eric M. USLANER, https://www.ritsumei.ac.jp/acd/re/k-rsc/lcs/kiyou/pdf_28-1/RitsIILCS_28.1pp.183-191USLANER.pdf
- 'Do natural disasters enhance societal trust?', Hideki Toya and Mark Skimore, 2013, https://www.researchgate.net/publication/254397933_Do_Natural_Disasters_Enhance_Societal_Trust
- 'Natural disaster and political trust: A natural experiment study of the impact of the Wenchuan earthquake', Yu You, Yifan Huang, Yuyi Zhuang, 2020. <https://journals.sagepub.com/doi/full/10.1177/2057150X19891880>
- Opinion: Civic engagement, innovation needed in disaster-recovery and reconstruction process | Devex
- IFRC, Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлэх нөлөө: Монгол улсын үнэлгээ, 2021, https://www.climatecentre.org/wp-content/uploads/RCRC_IFRC-Country-assessments-MONGOLIA-V8.pdf
- Mongolia Overview: Development news, research, data | World Bank